



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс

авсан 2024 оны 02 сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс



Дүгнэлт: Орхон аймаг Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 105 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 71 иргэн буюу 67.6% эмэгтэй, 34 иргэн буюу 32.4% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-29 насны 9 иргэн буюу 8.6% , 30-39 насны 49 иргэн буюу 46.7% , 40-49 насны 15 иргэн буюу 14.3% , 50-59 насны 25 иргэн буюу 23.8%, 60-аас дээш насны 7 иргэн буюу 6.7% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 105 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 30 иргэн буюу 27.0%, тэтгэмж 13 иргэн буюу 13%, сайн дурын даатгал 14 иргэн буюу 13.3%, нийгмийн даатгалын шимтгэл 20 иргэн буюу 19%, зөвлөгөө мэдээлэл 5 иргэн буюу 4.8%, бусад 23 иргэн буюу 22.9% тус бүр байна.


Хүснэгт1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар

		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын байгууллага үйлчилгээ шуурхай, хялбар байсан уу%	Маш сайн	101	96.2%
	Сайн	4	3.8%
	Дунд	-	-
	Муу	-	-
	Маш муу	-	-
Нийт үр дүн		105	100%

Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 101 даатгуулагч маш сайн үнэлгээг өгсөн (96.2%), сайн үнэлгээг 4 даатгуулагч буюу (3.8%), дунд, муу, маш үнэлгээг өгөөгүй байна.




Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл авсан үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 105 иргэн буюу (100%), “Үгүй” гэсэн үнэлгээг сонгоогүй байна.

Зураг 2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 105 иргэн буюу (100%) тус бүр өгсөн байна.




Зураг4:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа ..



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 105 иргэдийн “Тийм” үнэлгээг 9 иргэн буюу (8.6%),”Үгүй” үнэлгээг 53 иргэн буюу (50.5%),Мэдэхгүй үнэлгээг 43 иргэн буюу (41%) тус бүр үнэлсэн байна.


График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 105 иргэдийн “Тийм “үнэлгээг 1 иргэн буюу (0.5%),”Үгүй” үнэлгээг 104 иргэн буюу (99%) тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна .Тийм хэмээн хариулсан 1 иргэн каноны үйл ажиллагааны хураамжыг ойлгосон хэмээн авч үзэж байна.



График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив тусалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон “Үгүй” үнэлгээг 105 иргэн буюу (100%) тус бүр үнэлсэн байна.

Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?



- ✓ Сайн
- ✓ Маш их баярлалаа
- ✓ Маш их баярлалаа
- ✓ Түргэн шуурхай ажилласанд баярлалаа
- ✓ Шударга шуурхай байсанд баярлалаа
- ✓ Сайн үйлчилгээ үзүүлсэн
- ✓ систем хэвийн болгох
- ✓ систем хэвийн болгох
- ✓ систем хэвийн болгох

Судалгааны нэгтгэл хийсэн:/Ө.Нэргүй /